


Хүүхдэд зориулсан Библи

танилцуулж байна



Бурханы хүчит эр Самсон

Зохиогч: Edward Hughes
Зураглаач: Janie Forest

Орчуулсан: Damdin Horolsuren
Найруулсан: Lyn Doerksen

Түүх 14/60

www.M1914.org

Bible for Children, PO Box 3, Winnipeg, MB R3C 2G1 Canada

Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах эрхтэй харин худалдахыг хориглоно.

Монгол хэл


Mongolian

Эрт урьдын цагт Израйл нутагт Маноа гэдэг нэгэн хүн амьдардаг байв. Тэр эхнэр авсан ч хүүхэдгүй байлаа. Нэгэн өдөр Эзний тэнгэр элч Манаогийн эхнэр дээр хүрч ирээд "Чи удахгүй хүүхэдтэй болох бөгөөд тэр маш онцгой нэгэн болно" гэв.




Тэр эмэгтэй нөхөртөө энэ гайхамшигтай мэдээг хэлэв. Маноа "Өө Эзэн минь Бидэн уруу дахин ирээч, Бид төрөх хүүхдийн төлөө юу хийх ёстойг заагаач" хэмээн залбирчээ.





Тэнгэр элч Манаод Бурхан энэ хүүхдийг шүүгчээр сонгосон бөгөөд тэр Израилийг удирдах болно гээд түүний үсэнд хэзээ ч мэс хүргэж үл болно мөн тэр архи болон бузар хоол хүнс идэж болохгүй гэжээ.




3



Энэ үед Бурханы ард түмэнд гарцаагүй тусламж хэрэгтэй байв. Тэд Бурханыг орхисон бөгөөд тэдний дайсан болох Филлистичүүд тэднийг дарлан байлаа. Харин тэд Бурханд залбирсан бөгөөд Бурхан тэднийг сонсжээ. Тэгээд Бурхан энэ хүүг дэлхийн хамгийн хүчтэй эр болох болно гээд хүүг тэдэн уруу илгээжээ.

4




Харин тэд Бурханд залбирсан бөгөөд Бурхан тэднийг сонсжээ. Тэгээд Бурхан энэ хүүг дэлхийн хамгийн хүчтэй эр болох болно гээд хүүг тэдэн уруу илгээжээ.

5



Ийнхүү эмэгтэй хүүг төрүүлж Самсон гэдэг нэр өгөв. Хүү өсөж Бурхан түүнийг ерөөжээ. Хүү өсөж Бурханы сүнс түүний сэтгэлийг хөдөлгөх болжээ. Самсон агуу хүчит эр болов. Нэгэн өдөр тэр залуу арслангай тулалдаад түүнийг алав.

6



Нэгэн өдөр түүний алсан өнөөх арслангийн сэгэнд зөгий үүрлэн бал байхыг хараад Самсон балнаас авч идэв. Тэгээд тэр нэгэн оньсого зохиожээ. "Идэгчээс идэх юм гарав. Хүчтэнээс амттай зүйл гарав."

7



Онсьогын хариуг хэн ч олсонгүй харин Самсоны Филлистчүүдаас авсан эхнэр нь нөхрөөсөө хариултыг нь асуугаад найзууддаа хэлж өгчээ. Самсон үүнд маш их уурлав.


8

Удалгүй Филистчүүд түүний эхнэрийг найзад нь эхнэр болгон өгсөнд Самсон ихэд уурлав. Тэр тэднээс өшөөгөө авахаар төлөвлөжээ. Гэвч яаж? Эхлээд Самсон гурван зуун үнэг барив. Тэгээд тэднийг сүүл сүүлээр нь холбож хоёр сүүлний хооронд бамбар уяв.




9

Самсон тэднийг Филистчүүдийн тариан талбайд оруулав! Тэдний бүх ургац шатжээ.



10

Филистчүүд түүнээс өшөөгөө авахыг хүсэж байлаа. Самсон өөрийгөө хүлээд Филистчүүдэд өгөхийг зөвшөөрчээ.




11

Гэтэл Бурханы сүнс Самсон дээр хүчтэй буув. Тэрээр хүлсэн олсоо тастаад үхээд удаагүй илжигний эрүүний яс олж мянгаад дайснаа устгав.



12

Филистчүүдийн цэргүүд Самсоныг хайж байв. Нэгэн шөнө тэд түүнийг барихаар хотын хаалгыг түгжжээ. Гэвч Самсон шөнө дөлөөр гарч хотын хаалгыг булга татан хоёр мөрөн дээрээ тэгнэн зугтжээ.



13

Гэвч Самсон Бурханы өмнө буруу зүйл хийсэн байлаа. Бурхан амласныхаа дагуу түүнд агуу хүч чадлыг өгсөн юм. Нэгэн өдөр Самсон өөрийн хүч чадлын нууцыг Делила гэдэг Филистчүүдийн тагнуул эмэгтэйд хэлчхэж гэнэ.



14

Тэр түүнд дурласан байв.
Ингээд тэр эмэгтэй
Самсоныг унтаж байх
зуур түүний үсийг хусжээ.



15

Удалгүй
Филистчүүдийн
цэргүүд Делилагын
унтлагын өрөөнд
байсан Самсонруу
дайрав. Самсон тэдэн
уруу дайрсан боловч
түүний хүч алга болсон
байв. Дайснууд түүний
нүдийг сохолжээ.



16

Сохор бас хүч
чадалгүй дорой
болсон Самсон
Филистчүүдийн зарц
болов. Тэд Бурханы
үйлчлэгчийг
доромжилж түүгээр
тоглоом хийж
инээлддэг байлаа.



17


Сохор бас хүч
чадалгүй дорой
болсон Самсон
Филистчүүдийн зарц
болов. Тэд Бурханы
үйлчлэгчийг
доромжилж түүгээр
тоглоом хийж
инээлддэг байлаа.



18

Нэгэн хүү Самсоныг хөтлөн ирж түүнийг дуганы
баганыг түшүүлэн зогсоов. Тэнд гурван мянга гаруй
Филистчүүд байсан бөгөөд бүгд түүнийг хараад

шоолон
инээлдэж
байв.




19

Харин Самсоны үс хусуулснаасаа хойш шоронд байх
зуур ургаж эхэлсэн байв.




20

Тэгээд Самсон ийнхүү залбирав "Эзэн БУРХАН минь, намайг санан соёрхооч.




21

Бурхан минь, зөвхөн энэ удаа л надад хүчийг өгөөч. Би ганцхан л удаа хоёр нүднийхээ төлөө филистчүүдээс өшөөгөө авъя" хэмээв.



22

Бурхан Самсонд хүч чадлыг дахин өгсөн болов уу? Самсонд энэ боломжтой болов уу? Тийм ээ! Тийм! Тэр хүч чадал орж дуганы хоёр баганыг хоёр гараараа түлхэв.



23

Тэр даруй дуган нурж дотор нь байсан Самсон болон мянга гаруй филистчүүд бүгд дарагдан нас баржээ.



24

Бурханы хүчит эр Самсон

Бурханы үг Библээс авсан түүх

Шүүгчид 13-16

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл юм.

Бурхан бидэнд маш их хайртай Тэрээр өөрийн хүү Есүсийг бидний гэмийн төлөөс болгон загалмайн үхэлд тушаасан. Есүс дахин амилж мөнхийн улсдаа буцсан! Одоо Бурхан бидний гэмийг уучилж чадна.

Хэрвээ та гэмээсээ эргэхийг хүсвэл, Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Бурхан минь ээ, Би Есүс миний төлөө үхээд дахин амилсан гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач тэгээд би шинэ амьдралаар амьдарч дараа нь тантай хамт мөнхөд амьдрах болно.

Таны хүүхэд шиг Таны төлөө амьдрахад туслаач.

Амен Иохан 3:16

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай!